



**БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс: 7034-2580
E-mail: bulgan@audit.gov.mn

2024.08.19 № 659
танай _____ ны № _____ т

**БУЛГАН АЙМГИЙН БУГАТ
СУМЫН СОНГУУЛИЙН ХОРООНД**

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх
дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Х.Хүрэлбаатарын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

2024 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-

006021330

2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.


Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч Х.Хүрэлбаатар Бугат сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Х.Хүрэлбаатарын мөрийн хөтөлбөр (.../.....хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Х.Хүрэлбаатард

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.ЭРДЭНЭ

БУЛГАН АЙМГИЙН БУГАТ СУМЫН 2024 ОНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ХИШИГСҮРЭНГИЙН ХҮРЭЛБААТАРЫН
МӨРИЙН ХӨТӨЛБӨР

- 1.1 Мал сүргийн эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх бодлогыг дэмжинэ.
- 1.2 Газар зохион байгуулалтын төлөвлөлт, газар ашиглалтыг сайжруулж, газрын зөрчлийг арилгах ажлыг бодлогоор дэмжинэ.
- 1.3 Залуучуудад бизнес эрхлэхэд шаардлагатай орчин нөхцлийг бүрдүүлэх, бодлогыг дэмжинэ.
- 1.4 Сумын хүн амын ундны болон ахуйн хэрэгцээний уст цэгийн төлөвлөлт, байршил, ашиглалт, хамгаалалтыг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.5 Уламжлалт бэлчээрийн мал аж ахуйд малын төрөл хоорондын харьцаа, сүргийн зохистой бүтцийг бүрдүүлэх бодлогыг дэмжинэ.
- 1.6 Иргэдийн ногоон тэмжээл тариалах үйл ажиллагааг идэвхжүүлэх, өвс тэжээлийн аюулгүй нөөцийг бүрдүүлэх, нөхцөлийг сайжруулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.7 Багийн худаг уст цэгийн тоог нэмэгдүүлэхэд бодлогыг дэмжинэ.
- 1.8 Хээлтүүлэгч малын чанарыг сайжруулах, эрүүл мэндийн үзлэгт тогтмол хамруулах бодлогыг дэмжинэ.
- 1.9 Багийн эмчийн хүрэлцээ хангамж, ⁶³¹⁷¹⁴⁵⁷ эргэлтийн эмийн сангийн үйл ажиллагааг ^{ГЮА0048 3190269} тогтмолжуулах бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.10 Малчдыг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах, алслагдсан багийн иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээг ойртуулах бодлогыг дэмжинэ.
- 1.11 Өрхийн үйлдвэрлэл эрхлэх хүсэлтэй иргэдийг зээлийн хөтөлбөрт хамруулах замаар өрхийн амжиргааны төвшинг дээшлүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ.
- 1.12 Жижиг дунд үйлдвэрлэл, гар урлал эрхлэгчдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, бэлэг дурсгалын зүйлсийг борлуулахад бодлогын дэмжлэг үзүүлнэ.

МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН:

А. Ауртбаатар

/Х.ХҮРЭЛБААТАР/ 95587480